

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны
5 дугаар сарын 28-ны өдрийн 69 дүгээр
тогтоолын хавсралт

ХОВД АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Аялал жуулчлалын үйлдвэрлэл нь аливаа улс орны хувьд зөвхөн эдийн засгийн нэгэн салбар төдийгүй, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагаа, нийгэм-соёлын хөгжил, уламжлалт зан заншил, байгаль орчноо хадгалан хамгаалах үйл явцыг орчин үеийн шинжлэх ухаан, технологийн дэвшлийг хослуулан хөгжүүлэх боломжийг олгодог.

1999 онд Монгол Улсад Үндэсний Аялал Жуулчлалыг хөгжүүлэх “Мастер төлөвлөгөө”, 2000 онд УИХ-аас “Аялал жуулчлалын хууль”-ийг батлан гаргаж эрх зүйн орчинг бүрдүүлж эхэлсэн.

Манай аймгийн хувьд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2002 оны 100 дугаар тогтоолоор “Ховд аймгийн байгалийн аялал жуулчлал /эко туризм/-ыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг /2002-2006 он/, Баруун бүсийн III зөвлөгөөний шийдвэрээр “Баруун бүсийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн хөтөлбөр” /2007-2015 он/-ийг баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ажилтай, орлоготой монгол хүн-бүлгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого”, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэгт аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тусгасан байна.

Ховд аймгийн нутаг дэвсгэр нь байгалийн мөнх цас, мөсөн голоос эхлээд говь, цөл бүхий үзэсгэлэн бүрдсэн, байгалийн олон бүс бүслүүрүүд бүхий газрууд, түүх дурсгалт хөшөө дурсгал, өвөрмөц сонин тогтоцтой газрууд олонтой төдийгүй нүүдэлчдийн ахуй, соёл иргэншил, байгальтайгаа зохицон амьдарч ирсэн уламжлал, өөрийн гэсэн хэв маягтай бөгөөд эдгээр нь аялал жуулчлалыг хөгжүүлэх үндсэн бааз суурь нь болдог.

2012 онд Аялал жуулчлалын үндэсний төвөөс Гадаадын жуулчид яагаад Монгол орныг аялахаар сонгож байна вэ? гэдэг шалгааныг тодруулах зорилгоор авсан санал асуулгын дүнгээс харахад

1) нүүдэлчдийн түүх соёл,

2) Унаган байгаль,

3) Адал явдалт аялалыг сонирхон сонгосон гэсэн дүн гарсан байдаг. Мөн Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын “Аялал жуулчлал 2020 онд” судалгаанаас үзэхэд XXI зуунд аялал жуулчлалын дараах 5 төрөл давамгайлан хөгжих төлөвтэй гэсэн дүн байдаг. Үүнд:

-Адал явдалт жуулчлал – Adventure tourism

-Эко жуулчлал – Ecotourism

-Тусгай сонирхлын жуулчлал – Special interest tourism

-Тойрон аялал – Round trip

-Соёл-танин мэдэхүйн жуулчлал – Culture tourism

Манай аймгийн тухайд эдгээр аялалуудыг хөгжүүлэх бүрэн нөөц боломжтой. Тухайлбал, Монгол Алтайн нурууны мөнх цас мөсөн гол бүхий өндөр уул нурууд, Хар-Ус, Хар, Дөргөн нуур, Шижигтэйн хавцал, Ховд, Булган голуудыг түшиглэн адал явдалт, тусгай сонирхлын, эко аялал жуулчлалыг, харин олон угсаатны зан заншил, түүх соёлын дурсгалууд дээр тулгуурлан соёл-танин мэдэхүйн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Сүүлийн жилүүдэд Ховд хотод бүтээн байгуулалтын чиглэлээр олон зүйлийг хийж байгаатай холбоотой хотын аяллыг зохион байгуулах боломж бүрдээд байгаа. Тухайлбал, өнгө үзэмж, гүйцэтгэх үүргийн хувьд жуулчдын сонирхлыг татах, зураг авахуулах боломжтой “Эв эеийн суврага”, “Ганданпунцагчойлин хийд”, “Хүүхэд залуучуудын парк”, “Домбо”, “Монгол гутал” зэрэг үзмэрүүд бий болж байна.

2009-2013 онуудад “Өлгий” олон улсын агаарын замын боомтоор 1834, “Даян” авто замын боомтоор 116, “Цагааннуур” олон улсын авто замын боомт 77675, “Боршоо” авто замын боомтоор 45952, “Бургастай” авто замын боомтоор 71187, “Булган” олон улсын авто замын боомтоор 15319 гадаадын иргэн орж ирсэн судалгаа байна.

Ховд аймгийн тухайд сүүлийн 5 жилийн судалгааг авч үзвэл 2009 онд 1040, 2010 онд 1352, 2011 онд 1623, 2012 онд 1592, 2013 онд 1000 гадаад жуулчин ирж, 50.0 сая төгрөгний орлого оруулсан гэсэн судалгаа гарсан.

Дотоодын жуулчдын хувьд 2009 онд 6500, 2010 онд 10476, 2011 онд 14297, 2012 онд 12399, 2013 онд 10000 жуулчин ирсэн судалгаа байна.

Жуулчдын дийлэнх хувь нь судалгаа шинжилгээний ажил хийх, хурал зөвлөгөөнд оролцох, дайран өнгөрөх, тусгай сонирхлын ан агнах, баяр наадам үзэх, аялал хийх зорилгоор манай аймгийг зорьсон байна.

Аялал жуулчлал нь хүний төлөө үйлчилж байх ёстой механизм бөгөөд өндөр чанартай үйлчилгээг хүмүүст хүргэж “сэтгэгдэл” үлдээх замаар хийгддэг бизнес бөгөөд энэхүү салбарт ажиллагсдаас нарийн мэдлэг, ур чадвар, бүтээлч хөдөлмөрийг шаарддаг. Дэлхийн хэмжээнд 10 ажлын байр тутмын нэг нь аялал жуулчлалын салбарт хамаардаг бол нэг жуулчин хүлээн авахад 20 ажлын байр идэвхждэг гэсэн дэлхийн Аялал жуулчлалын байгууллагын судалгаа бий.

Ховд аймагт 12 аж ахуйн нэгжид нийт 103 ажиллагсад байдгаас мэргэжлийн 35, түр ажиллагсад 68 байна. Үүнээс харахад үйлчилгээний салбарын ажиллагсдыг чадавхижуулах, мэргэшүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна.

Аялал жуулчлалын салбар хөгжиж, жуулчдын тоог нэмэгдүүлэхийн тулд дэд бүтцийн өнөөгийн нөхцөл, жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадал, үйлчилгээний чанар хангалтгүй, жуулчны улирлын хугацаа богино, жуулчдад зориулсан үзвэр дутмаг, үзвэр үйлчилгээний хуваарь мэдэгдэхгүй зэрэг дутагдлууд гарсаар байна.

Эдгээрээс үндэслээд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардагдах дэд бүтэц, аялал жуулчлалын цогцолбор байгуулах, үйлчилгээний чанарыг сайжруулах, аялал жуулчлалын үргэлжлэх хугацааг уртасгах, аялал жуулчлал эрхлэгчдийн хамтын ажиллагааг сайжруулах зэрэг нэн тэргүүний асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор “Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр”-ийг боловсруулж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Монгол Алтайн мөнх цаст сүрлэг өндөр уулсаас говь цөлийн хэв шинж бүрдүүлж байгалийн унаган төрхөө хадгалан үлдсэн үзэсгэлэнт байгаль, угсаатны бүлгүүдийн ахуй амьдрал, зан заншил, нүүдэлчдийн түүх соёлд тулгуурлан олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлж, аймгийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг, эзлэх байр, үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд

3.1. Байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, нэн ховор, ховор амьтан, ургамал, түүх соёлын дурсгалт зүйлс, олон угсаатны өв соёлын судалгаа хийж, орон нутаг, бүс, улс, дэлхийн хэмжээнд сурталчлах;

3.2. Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, салбарын ажиллагсдыг чадавхижуулах, мэргэшүүлэх, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг бий болгох;

3.3. Төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтран ажиллах боломжтой хэлбэр, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих замаар аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

3.4. Бүс нутгийн болон хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх;

3.5. Байгальд ээлтэй дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар аялал жуулчлалын үр ашгийг орон нутаг, иргэдэд хүртээмжтэй болгох, аялал жуулчлалын үзмэрүүдийг бий болгох, аймгийн нутгаар аялах аяллын маршрутыг аяллын төрөл тус бүрээр нарийвчлан тодорхойлж, баталгаажуулан тэмдэгжүүлэх.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Зорилт 1-ийн хүрээнд:

4.1.1. Аймгийн нутаг дэвсгэр дээр байгаа түүх соёлын дурсгалууд, байгалийн үзэсгэлэнт газрууд, нэн ховор, ховор амьтан, ургамал, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газрууд зэргийн судалгаа, бүртгэл хийж мэдээллийн санд оруулах;

4.1.2. “ITM” зэрэг аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд оролцох;

4.1.3. Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх зорилгоор олон улсын, улсын, бүсийн чанартай эвент арга хэмжээг бий болгож, тогтмол зохион байгуулж хэвших;

4.1.4. Аялал жуулчлалын бие даасан цахим хуудастай болох;

4.1.6. Жуулчдад зориулсан соёл урлагийн тоглолтуудын хөтөлбөрийг тодорхой болгож, ардын урлагийг сурталчилсан хамтлагуудыг бий болгох;

4.1.7. Аймгийн онцлог, эвент арга хэмжээнүүд, аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүд, аяллын маршрутууд, үйлчилгээний байгууллагууд зэрэг жуулчдад зориулагдсан мэдээллүүдийг багтаасан сурталчилгааны материал, гарын авлага, гэрэл зургийн цомог, аяллын газрын зураг, бэлэг дурсгалын зүйлс зэргийг бий болгох.

4.2. Зорилт 2-ын хүрээнд:

4.2.1. Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээг олон улсын стандартын түвшинд хүргэж, ажиллагсдыг чадавхижуулах, мэргэжлийн боловсон хүчний хангамж, ур чадварыг сайжруулах үе шаттай сургалтуудыг зохион байгуулах;

4.2.2. Салбарын ажиллагсдын үйл ажиллагааг сурталчилсан өдөрлөг, уралдаан тэмцээн зохион байгуулах;

4.2.3. Жуулчдын аюулгүй байдлыг хангах, үнэн зөв мэдээллээр үйлчлэх зорилгоор жуулчин тээвэрлэх жолооч болон хөтөч тайлбарлагчийн бүртгэл хийж, сургалтанд хамруулж, хамтран ажиллах.

4.3. Зорилт 3-ын хүрээнд:

4.3.1. Хар-Ус нуурын бүсэд аялал жуулчлалын цогцолбор байгуулах;

4.3.2. Амралтын газар, жуулчны баазууд хүрэх замыг тэмдэгжүүлэх;

4.3.3. Аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулах;

4.3.4. Орон нутагт аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудаас хөрөнгө оруулалтыг татаж хамтран ажиллах.

4.4. Зорилт 4-ийн хүрээнд:

4.4.1. Алтайн бүс нутгийн улс орнуудтай гэрээ байгуулж хамтран ажиллах, нэгдсэн маршруттай болох;

4.4.2. Хил орчмоор аялах аяллын маршрут бий болгох;

4.4.3. Баруун бүсийн нутгаар аялах аяллын маршрут бий болгох.

4.5. Зорилт 5-ын хүрээнд:

4.5.1. Байгальд ээлтэй хариуцлагатай аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх гэр баазууд байгуулах;

4.5.2. Олон угсаатны ахуй амьдрал, зан заншил зэрэгт тулгуурлан нутгийн иргэдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд татан оролцуулж амьжиргааг нь дээшлүүлэх;

4.5.3. Аймгийн нутгаар аялах аяллын маршрутыг төрөл тус бүрээр гаргаж, тэмдэгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

“Аялал жуулчлал” хөтөлбөр 2014-2018 онуудад хэрэгжинэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, зохицуулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс хариуцана.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймгийн Соёл, спорт, аялал жуулчлалын газар, театр, музей, номын сан, сумдын ЗДТГ, соёлын төвүүд, аймгийн аялал жуулчлалын холбоод олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулна.

6.3. Жил тутам хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн, шилдэг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг шалгаруулан дараагийн зорилтыг тодорхойлж байх.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

1. Улсын болон орон нутгийн төсөв;
2. Орон нутгийн хөгжлийн сан;
3. Аж ахуйн нэгж, хувийн хэвшил, олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрийн байгууллага, иргэдээс оруулсан хандив тусламж;
4. Байгаль хамгаалах сан;
5. Хууль заасан бусад эх үүсвэрээс.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтээр тооцно.

д/д	Хүрэх үр дүн		Шалгуур үзүүлэлт					
			2013	2014	2015	2016	2017	2018
1	Аялал жуулчлалын салбараас орох орлогын хэмжээ нэмэгдсэн байх		50.0 сая.төг	60.0	70.0	80.0	90.0	100.0 сая. төг
2	Үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар сайжирсан байна	Мэргэжлийн ажиллагсадын тоо	30	40	50	60	70	90
		Жуулчдын тоо	1000	1500	2000	2500	3000	5000
		Одны зэрэглэлтэй буудал	-	-	-	1	1	2
3	Сум бүрт аялал жуулчлалын маршрут бий болж, нутгийн иргэдийг аялал жуулчлалын салбарт татан оролцуулна	Сум бүр маршруттай болсон байна	-	+	+	+	+	+
		Сум бүр аялал жуулчлалын бүс тогтоосон, аяллын төрлүүдээр аялал зохион байгуулж	-	+	+	+	+	+

		хэвшсэн байна.						
		НИТАЖ хөгжинө		+	+	+	+	+
4	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа	Аялал жуулчлалын холбоо байгуулна	-	+	+	+	+	+
5	өргөжин, аймгийн “Аялал жуулчлалын холбоо” байгуулагдан үйл ажиллагаа нь тогтворжсон байна	Салбарын ажиллагсдыг чадавхижуулах сургалт, сурталчилгааны ажлуудыг хамтарч хийдэг болох	-	+	+	+	+	+